



ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2012/02

Улаанбаатар хот
2012 он



ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуйн салбар	2
2. Аж үйлдвэрийн салбар	7
3. Хүнсний үйлдвэрийн салбар	9
4. Цаг агаар	12

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.



МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Том малын зүй бус хорогдол 2012 оны эхний 2 сард улсын хэмжээнд 61.0 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 73.4 мян. толгой буюу 54.6 хувиар буурсан байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 3.1 мянга, үхэр 6.1 мянга, тэмээ 87. хонь 22.4 мянга, ямаа 29.3 мянга байна. Нийт хорогдлын 36.7 хувийг хонь, 48.0 хувийг ямаа эзэлж байна.

2012 оны эхний 2 сард Архангай аймагт оны эхэнд тоологдсон малын 0.5 хувь буюу 15.6 мянга, Ховд аймагт 0.5 хувь буюу 8.3 мянга, Увс аймагт 0.3 хувь буюу 4.7 мянга, Говь-Алтай аймагт 0.3 хувь буюу 4.7 мянга, Хөвсгөл аймагт 0.1 хувь буюу 4.1 мянга, Баянхонгор аймагт 0.2 хувь буюу 3.8 мянга, Төв аймагт 0.1 хувь буюу 2.9 мянга нь хорогдлоо. Улсын хэмжээнд хорогдсон малын 72.2 хувийг эдгээр аймагт хорогдсон мал эзэлж байна.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 2 сард 2.1 мян.мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 0.9 мян.толгой буюу 30.0 хувиар буурсан байна.

Зүй бусаар хорогдсон том мал /жил бүрийн эхний 2 сарын байдлаар/

Төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 ^{I-II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	2010 ^{I-II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}
Бүгд	3397.4	134.4	61.0	7.7	0.4	0.2
Тэмээ	2.1	0.2	0.1	0.8	0.1	0.0
Адуу	110.7	5.2	3.1	5.0	0.3	0.2
Үхэр	186.4	11.2	6.1	7.2	0.5	0.3
Хонь	1196.2	50.6	22.4	6.2	0.3	0.1
Ямаа	1901.9	67.2	29.3	9.7	0.5	0.2

МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ

Манай оронд цас их орж, хүйтрэн өвөлжилт хүндэрч, гурван жил дараалан зуд нүүрэлсэн жилүүд 1966-1968 он, 2000-2002 онд тохиолдож байв. Зүй бус хорогдсон том мал 1966-1968 онд 6.6 сая толгой, 2000-2002 онд 11.2 сая толгой байсан бол 2009-2011 онд 12.7 сая толгой болж нэмэгдсэн байна.

Мал өвөлжилт, хаваржилт 2010 онд өмнөх жилүүдээс хүндэрч, 10.3 сая толгой том мал зүй бусаар хорогдож байсан бол 2011 онд 0.7 сая толгой том мал зүй бусаар хорогджээ. Зах зээлийн эдийн засгийн үе болох 2011 оныг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үе 1963 оныхтой харьцуулбал, манай улсын нийт малын тоо 1.6 дахин, үүний дотор ямааны тоо 3.2 дахин, хонины тоо 24.0 хувь, үхрийн тоо 26.0 хувиар нэмэгдсэн байна. Харин энэ хугацаанд



тэмээний тоо 60.1 хувь буюу 2.5 дахин, адууны тоо 8.0 хувиар буурчээ. Малын тооны нийт өсөлтийн 79.1 хувийг зөвхөн ямааны тооны өсөлтөөр хангасан байна.

Нийт сүрэгт бод малын эзлэх хувь 1963-1965 онд дунджаар 21.9 байсан бол 2000-2002 онд 18.4, 2009-2011 онд 12.6 болж, сүүлийн 50 орчим жилд 8.6 пунктээр буурч, энэ хэмжээгээр бог малынх нэмэгджээ. Ялангуяа ямаан сүргийн эзлэх хувь дунджаар 1963-1965 онд 20.9 байсан бол 2000-2002 онд 36.2, 2009-2011 онд 43.8 болж, 21.8 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт сүрэгт төл, өсвөр насны малын эзлэх хувь 1963-1965 онд дунджаар үхэрт 47.5 хувь, бусад малд 32.5-36.5 хувийг эзэлж байсан бол 2009-2011 онд дунджаар үхэрт 43.8 хувь, бусад малд 26.3-38.0 хувийг эзлэх болжээ. Энэ хугацаанд үхэр сүрэгт хээлтэгчийн эзлэх хувийн жин 41.6 хувь байснаа 40.5 хувь болж, хонь, ямаанд хээлтэгчийн эзлэх хувь 49.5- 49.8 хувь байснаа 45.1-46.3 хувь болж буурсан нь эр сувай малын эзлэх хувь нэмэгдсэнээс шалтгаалжээ. Эр сувай малын нийт малд эзлэх хувь 1963-1965 онд дунджаар бог малд 12.8-14.7 байснаа 2009-2011 онд 22.0-28.0 болж, 9.2-13.3 пунктээр нэмэгдэв.

Эр сувай малын тооны 2009-2011 оны дунжийг 1963-1965 оныхтой харьцуулахад үхэр сүргийн хувьд 1.8 дахин, хонинд 2.1 дахин, ямаанд 6.5 дахин нэмэгдсэн байна.

Нийт хээлтэгч малын тоо 2011 онд 2000 оныхоос 18.5 хувь нэмэгдсэний дотор эм ямааны тоо 46.4 хувь, эм хонины тоо 10.9 хувь, ингэний тоо 1.5 хувиар өссөн байна. Харин гүүний тоо 22.1 хувь, үнээний тоо 20.5 хувиар хорогджээ. Энэ хугацаанд нийт хээлтэгч малын өсөлтийн 88.9 хувийг зөвхөн эм ямааны тооны өсөлтөөр хангасан байна.

Төллөвөл зохих хээлтэгчид хээл хаяж, сувайрсан гүүний эзлэх хувь 1963-1965 онд дунджаар 30.9 хувь байснаа 2000-2002 онд 34.5 хувь болсон нь гурван унага тутмын нэг буюу түүнээс ч илүүг бойжуулах боломж алдсан гэсэн үг юм. Зуднаар 2000-2002 онд дөрвөн үнээний нэг нь, таван ямааны нэг нь хээл хаяж, сувайрчээ.

Харин 2000-2002 онд дунджаар, оны эхний тоологдсон малын 12.4 хувьтай тэнцэх нийт 11.2 сая мал хорогдсоны дотор таван үхэр тутмын нэг нь буюу 1.8 сая толгой үхэр зуданд хорогдсон байна.

Оны эхний тоологдсон малын дунджаар 10.6 хувьтай тэнцэх 12.7 сая мал 2009-2011 онд зүй бусаар хорогдлоо.

Өвчнөөр хорогдсон малын нийт малын хорогдолд эзлэх хувь 2000-2002 онд дунджаар 7.4 хувь, 2009-2011 онд 2.7 хувь болсон байна.

Хээлтүүлэгч малын тоо 2011 онд 329.7 мян.толгой болж, 2000 оныхоос 12.2 мян.тол буюу 3.8 хувь, 2005 оныхоос 20.5 мян.толгой буюу 6.6 хувиар нэмэгджээ.

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ХАРЬЦАА

Хээлтэгч, хээлтүүлэгчийн харьцаа бод малын хувьд үржлийн нормын хэмжээнд байгаа боловч бог малд хуц, ухны тоо үржлийн нормоос 2 гаруй дахин цөөрч харьцаа алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2011 онд улсын дунджаар 63-70 эм хонь, ямаа ногдож, 2.1-2.8 дахин өндөр үзүүлэлт гарч байна.



Ямааны тоо 2009-2011 онд 1963-1965 оны дунджаас 3.4 дахин, үүнээс эр ямааны тоо 6.5 дахин өсчээ. Сүүлийн гурван жилийн дунджаар эр сувай ямааны тоо 4.6 саяд хүрснээс ноолуурын үйлдвэрлэлд гарц нь арвин байх талтай ч бүдүүн микронтой чанаргүй ноолуурын хэмжээг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна.

Өрхийн хүсэнд хэрэглэсэн болон зах зээлд худалдан борлуулсан малын тоо дунджаар 1963-1965 онд 5.1 сая, 2000-2002 онд 7.0 сая байсан бол 2008 онд 8.3 сая, 2009 онд 11.3 сая болж огцом өсчээ. Харин өрхийн хүсэнд хэрэглэсэн болон зах зээлд худалдан борлуулсан малын тоо 2011 онд 8.3 сая толгой болж, 2010 оныхоос 0.1 сая толгой буюу 0.9 хувь, 2009 оныхоос 3.0 сая толгой буюу 26.5 хувиар буурчээ.

2. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хонины нэхий, ямааны арьсны зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Хонины /ноостой/ нэхий, ширхэг			Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг		
	2011.И	2012.И	2012.И	2011.И	2012.И	2012.И
Баруун бүс						
Баян-Өлгий	8000	14800	15000	17000	21800	22000
Говь-Алтай	8000	19000	-	19500	23000	23800
Завхан	7500	19000	15000	18000	21000	22000
Увс	6500	-	13500	16000	20000	20500
Ховд	7500	15000	15300	18000	20000	22700
Хангайн бүс						
Архангай	7000	19000	17000	18000	21000	23000
Баянхонгор	5000	20000	18000	20000	27000	27000
Булган	7500	18000	13500	15500	21000	20500
Орхон	7000	19000	12000	17500	-	-
Өвөрхангай	8000	20000	11000	20000	23000	23000
Хөвсгөл	7000	19000	-	16000	21000	20000
Төвийн бүс						
Говьсүмбэр	8500	18500	15000	20000	22000	23500
Дархан-Уул	7000	19000	19000	19000	23000	23000
Дорноговь	8000	19000	15000	18000	22000	20000
Дундговь	8000	20000	17700	22000	25000	24300
Өмнөговь	5000	19000	15000	18000	24000	23000
Сэлэнгэ	5000	18000	18000	17000	20000	20000
Төв	7500	-	15000	17500	25000	25000
Зүүн бүс						
Дорнод	5000	-	13000	15000	21300	20700
Сүхбаатар	5500	17000	12000	15000	24000	22000
Хэнтий	5000	17000	10000	18000	25000	25000
Улаанбаатар						
Улаанбаатар	7000	16000	15000	19000	20000	19000



Үхрийн ширний зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Үхрийн шир, ширхэг					
	2 м-ээс доош урттай			2 м-ээс дээш урттай		
	2011.И	2012.И	2012.И	2011.И	2012.И	2012.И
Баруун бүс						
Баян-Өлгий	11000	22500	22500	-	27000	27000
Говь-Алтай	7500	-	19000	12500	28000	29000
Завхан	-	27800	25000	10000	35000	28000
Увс	11000	28000	20000	13000	30000	25000
Ховд	-	-	-	13000	27000	28300
Хангайн бүс						
Архангай	15000	31000	30000	25000	38000	35000
Баянхонгор	13000	25000	25000	-	30000	30000
Булган	12000	31000	31000	21500	37500	36500
Орхон	14000	31000	26000	20500	40000	35000
Өвөрхангай	-	-	25000	12000	30000	30000
Хөвсгөл	15000	25000	25000	22000	30000	35000
Төвийн бүс						
Говьсүмбэр	13000	25000	25000	25000	30000	30000
Дархан-Уул	9500	29000	29000	23000	36000	36000
Дорноговь	-	20000	-	14000	30000	25000
Дундговь	-	-	-	12000	28700	30000
Өмнөговь	11000	20000	-	-	-	-
Сэлэнгэ	12000	28000	28000	20000	38000	38000
Төв	13000	30000	30000	20000	40000	40000
Зүүн бүс						
Дорнод	12500	30000	29700	19500	35000	35000
Сүхбаатар	12500	30000	28000	19000	36500	35000
Хэнтий	14000	32000	30000	-	-	-
Улаанбаатар						
Улаанбаатар	15300	35000	35000	25000	41000	40000



Адууны ширний зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг			Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг		
	2011.II	2012.I	2012.II		2011.II	2012.I	2012.II
Баруун бүс				Төвийн бүс			
Баян-Өлгий	18000	43500	44500	Говьсүмбэр	25000	39000	37500
Говь-Алтай	20000	40000	39700	Дархан-Уул	24000	32000	32000
Завхан	20000	40000	35000	Дорноговь	24000	41000	35000
Увс	22000	35000	30000	Дундговь	-	42300	40700
Ховд	20000	40000	40000	Өмнөговь	21000	35000	40000
Хангайн бүс				Зүүн бүс			
Архангай	25000	40000	45000	Дорнод	20000	42000	40000
Баянхонгор	22000	40000	38000	Сүхбаатар	23000	45000	40000
Булган	19500	40500	27500	Хэнтий	23000	45000	40000
Орхон	24000	41000	36000	Улаанбаатар			
Өвөрхангай	22000	40000	40000	Улаанбаатар	25000	42000	40500
Хөвсгөл	24000	42000	40000				

Ямааны ноолуурын зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Ямааны ноолуур, кг					
	Цагаан			Бор		
	2011.II	2012.I	2012.II	2011.II	2012.I	2012.II
Баруун бүс						
Баян-Өлгий	-	50000	52000	40000	50000	52000
Говь-Алтай	45500	45300	45300	45500	45300	45300
Завхан	43000	45000	50000	43000	45000	50000
Ховд	45500	-	48000	42000	-	48000
Хангайн бүс						
Архангай	40000	55000	50000	40000	55000	50000
Баянхонгор	48000	45000	49000	48000	-	-
Орхон	45000	51000	40000	43000	50000	40000
Өвөрхангай	50000	47000	47000	50000	47000	-
Хөвсгөл	47000	63000	54000	48000	52000	55000
Төвийн бүс						
Говьсүмбэр	47000	-	-	-	-	-
Дархан-Уул	40000	40000	40000	40000	40000	40000
Дорноговь	46000	45000	45000	46000	45000	-
Дундговь	-	45000	-	48500	-	-
Өмнөговь	48000	46000	-	48000	46000	46000
Сэлэнгэ	42000	-	-	42000	-	-
Төв	50000	50000	55000	50000	50000	50000
Зүүн бүс						
Сүхбаатар	45000	-	-	45000	-	-
Хэнтий	50000	-	-	-	-	-
Улаанбаатар						
Улаанбаатар	47500	47000		47500	-	-



3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 2 сард 667.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 55.8 тэрбум төг буюу 9.1 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 2 сард оны үнээр 718.0 тэрбум төг болж, үүний 415.4 тэрбум төг буюу 57.9 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^{II}	2012 ^{II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	$\frac{2012^{I-II}}{2011^{I-II}}$ (%)
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн. 2005 оны зэрэгцүүлэх үнээр	120661.9	132999.9	267129.3	287756.4	107.7
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	27453.3	32636.5	69145.2	74807.1	108.2
Хүнсний бүтээгдэхүүн. ундаа үйлдвэрлэл	16654.1	22130.3	43587.4	49484.0	113.5
Тамхи үйлдвэрлэл	328.5	548.6	2504.3	1861.5	74.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	4681.6	4182.0	9507.5	8317.2	87.5
Хувцас үйлдвэрлэл. үслэг арьс боловсруулалт	577.0	383.0	1325.3	900.6	68.0
Арьс шир боловсруулах. ширэн эдлэл. гутал үйлдвэрлэл	16.8	92.1	55.5	198.2	357.3
Мод. модон эдлэл үйлдвэрлэл	159.5	160.7	338.8	308.7	91.1
Цаас. цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	117.8	239.1	279.9	484.2	173.0

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^{II}	2012 ^{II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	Үүнээс: гадаадад
Аж үйлдвэр. бүгд	337400.5	362576.5	628945.7	718001.3	415400.9
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	53788.3	98747.1	130289.1	204340.2	39722.1
Хүнсний бүтээгдэхүүн. ундаа үйлдвэрлэл	33810.0	47534.4	86850.7	117831.4	820.6
Тамхи үйлдвэрлэл	2200.0	3407.5	5700.0	6821.5	-



Нэхмэлийн үйлдвэрлэл	8955.4	8855.4	16015.1	13999.4	3593.5
Хувцас үйлдвэрлэл. үслэг арьс боловсруулалт	794.5	582.1	1768.2	1660.7	-
Арьс шир боловсруулах. ширэн эдлэл. гутал үйлдвэрлэл	36.3	82.3	97.2	168.3	-
Мод. модон эдлэл үйлдвэрлэл	575.1	627.5	1174.3	1256.1	-
Цаас. цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	690.9	826.5	1780.6	1598.5	-

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт




Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{II}	2012 ^{II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	$\frac{2012^{I-II}}{2011^{I-II}} \%$
Хивс	мян.м ²	65.3	73.8	135.3	158.7	117.3
Сүлжмэл эдлэл	мян.ш	48.2	40.9	104.0	85.9	82.6
Самнасан ноолуур	тн	25.1	5.2	29.4	12.4	42.2
Эсгий	мян.м	5.3	57.8	13.4	64.9	484.3
Тэмээний ноосон хөнжил	мян.м	3.9	0.4	6.3	2.1	33.3
Эсгий гутал	мян.хос	3.3	2.3	6.7	4.5	67.4
Нэхий дээл	ш	1075	394	3705	1835	49.5
Савхин гутал. ботинк	мян.хос	0.3	0.8	0.9	1.8	195.0
Барилгын модон хаалга. цонх	м ²	402.8	301.1	1152.3	633.7	55.0
Барилгын шалны банз	м ³	-	114.4	-	226.1	-
Зүсмэл материал	м ³	411.3	349.2	615.1	639.6	104.0
Дэвтэр	мян.ш	420.0	975.2	976.8	1988.9	203.6
Ариун цэврийн цаас	мян.ш	103.1	115.0	228.4	229.5	100.5
Бичгийн цаас	тн	24.1	4.2	47.9	4.2	8.8
Сонин	сая.х.д.х	2.7	3.6	5.7	7.9	138.3



4.ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^{II}	2012 ^{II}	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	$\frac{2012^{I-II}}{2011^{I-II}} \%$
Үхрийн мах	тн	59.6	3.9	172.2	440.0	255.5
Хонины мах	тн	56.3	-	227.8	409.9	179.9
Адууны мах	тн	2.0	-	54.4	16.8	30.9
Ямааны мах	тн	-	3.2	52.1	299.5	574.9
Гахайн мах	тн	0.8	1.0	1.7	2.7	158.8
Өлөн гэдэс	мян.гогцоо	67.4	142.8	144.3	202.5	140.3
Хиамны зүйл	тн	127.6	159.8	312.2	297.7	95.4
Боловсруулсан шингэн сүү	мян.л	1282.8	2530.1	3713.9	4829.6	130.0
Тараг	мян.л	437.2	218.7	955.7	703.1	73.6
Цөцгий, цөцгийн тос	тн	121.0	102.3	182.8	266.9	146.0
Аарц, бяслаг	тн	3.7	20.7	22.0	28.5	129.5
Дээд гурил	тн	365.0	278.7	5461.3	2377.4	43.5
Нэгдүгээр гурил	тн	2615.9	3987.7	12731.3	9560.1	75.1
Хоёрдугаар гурил	тн	483.3	556.2	1266.9	1077.9	85.1
Малын тэжээл	тн	956.7	1920.8	6477.8	4593.6	70.9
Нарийн боов	тн	593.8	1162.3	2004.9	2643.8	131.9
Талх	тн	1417.2	1846.8	3027.4	4076.5	134.7
Гоймон	тн	77.8	3.0	170.2	263.8	155.0
Спирт	мян.л	283.8	357.0	848.9	737.6	86.9
Архи	мян.л	2004.2	2143.9	4780.7	4786.7	100.1
Дарс	мян.л	13.9	10.0	21.2	15.7	74.1
Шар айраг	мян.л	3546.7	4877.5	7661.2	9956.2	130.0
Цэвэр ус	мян.л	1291.5	1664.0	2620.4	3677.5	140.3
Амтат ус, ундаа	мян.л	2713.0	3369.4	4956.2	6902.3	139.3
Жүүс	мян.л	2094.0	3810.2	4554.4	8055.6	176.9





Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	$\frac{2011^{I-II}}{2010^{I-II}} \%$
Адууны мах	т	25.8	192.1	745.8
Малын дайвар бүтээгдэхүүн	т	33.7	641.9	1906.3
Шеврет	сая дм ²	36.8	33.6	91.3
Шевро	сая дм ²	18.7	21.4	114.8
Адууны шир	мян.ш	63.9	38.6	60.4
Хонины самнаагүй ноос	т	2505.3	567.1	22.6
Бохир ноолуур	т	3.1	15.8	512.1
Самнасан ноолуур	т	15.6	22.6	145.3
Свитер. пуловер. джемпер. жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	1.1	2.8	261.6

Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{I-II}	2012 ^{I-II}	$\frac{2012^{I-II}}{2011^{I-II}} \%$
Өндөг	мян.ш	10047.4	10992.2	109.4
Төмс	т	10.3	39.5	383.9
Сонгино. сармис	т	1113.3	2041.8	183.4
Алим. лийр	т	802.9	472.9	58.9
Ногоон цай	т	408.8	435.5	106.5
Цагаан будаа	т	1343.4	1608.3	119.7
Улаанбуудай	мян.т	-	1.0	-
Гурил	мян.т	7.4	16.5	222.5
Ургамлын тос	т	325.2	1144.1	351.8
Элсэн чихэр	т	5074.8	5572.3	109.8
Хатуу чихэр	т	1060.9	993.7	93.7
Согтууруулах биш ундаа	мян.л	480.2	677.8	141.2



2012 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ**

УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

1979-2008 оны дунджаар дөрөвдүгээр сарын агаарын температурын дундаж нь Баян-Өлгийн өмнөд, Увс, Хөвсгөлийн хойд, Завханы хойд болон зүүн, Баянхонгор, Говь-Алтай, Архангайн баруун, Төв аймгийн зүүн, Хэнтийн баруун хойд хэсгээр 1 градус дулаанаас 3 градус хүйтэн, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Дорноговийн өмнөд хэсэг, Өмнөговийн ихэнх нутгаар 7-11 градус, бусад нутгаар 2-7 градус дулаан байдаг. Гэхдээ жил бүр адил байдаггүй. Тухайлбал, сүүлийн жилүүдийн байдлаар 1997-1999, 2004 онд 3-5 градусаар, 2000, 2001, 2005, 2007, 2008, 2009 онуудад 1-6 градусаар дулаан байж, өдөртөө баруун зүгийн нутгийн зүүн, төвийн нутгийн баруун хойд хэсгээр 16-21, говь ба зүүн зүгийн нутгаар 28-33, бусад нутгаар 21-26 градус хүрч дулаарч байсан бол 1991, 1993, 1995, 2010 онуудад ихэнх нутгаар, 2006 онд нутгийн зүүн хагаст олон жилийн дунджаас 1-5 градусаар хүйтэн байв. 1993, 2010 онд сарын эхээр Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 30-35 градус хүрч хүйтэрч байжээ.


Олон жилийн дунджаар Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь болон говийн нутгаар 1-5, Увсын зүүн, Архангайн өмнөд, Булган, Хэнтийн зүүн хойд, Дорнодын баруун хойд болон зүүн өмнөд хэсгээр 11-15, бусад нутгаар 6-10 мм хур тунадас ордог. Гэхдээ зарим жил олон жилийн дунджаас хэд дахин их буюу бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 1993, 1996, 1997, 2004 онуудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас харьцангуй бага хур тунадас орж, хуурайшилт ихтэй байсан бол 1998, 1999, 2010 онд говийн нутгаар, 2002-2003 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 2 дахин их хур тунадас оржээ.

Салхи 15 м/с-ээс давж шуурах нь тухайн сард дунджаар 3-5 удаа тохиолддог ч зарим жил 8-13 удаа ажиглагддаг байна. Сүүлийн жилүүдийн байдлаар 1998, 2001, 2002 онуудад баруун ба говийн нутгаар 34-45 м/с хүрч онц аюултай гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрч иргэд, байгууллагуудад ихээхэн хэмжээний хохирол учруулж байлаа.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Баруун зүгийн нутаг Энэ сард агаарын дундаж дундаж температур нутгийн хойд хэсгээр 2 градус хүйтнээс 3 градус дулаан, бусад хэсгээр 3-8 градус дулаан буюу Увс, Завханы нутаг, Баянхонгорын хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1 градусаар дулаан байна([3 дугаар зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр хүйтэрч Увс, Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 23-28, өдөртөө 3-8 градус хүйтэн, Алтайн өвөр говиор шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн ба эцэс, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 17-22 градус хүйтэн, өдөртөө 0-5 градус дулаан, Алтайн өвөр говиор шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 4-9, өдөртөө 19-24 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1 градус дулаанаас 4 градус хүйтэн, өдөртөө 14-19 градус хүрч дулаан байх төлөвтэй. Бусад хугацаанд Увс, Завхан, Баянхонгорын хойд хэсгээр шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан, Алтайн өвөр говь, Их

нууруудын хотгороор шөнөдөө 0-5, өдөртөө 13-18 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус дулаан байна.



Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Баян-Өлгийн ихэнх нутаг, Ховдын хойд, Завханы баруун өмнөд, Говь-Алтайн зүүн өмнөд, Увс, Баянхонгорын өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Ховдын өмнөд, Говь-Алтайн баруун болон хойд, Завханы зүүн хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үеэр нь ихэнх нутгаар цас орно. Хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орно. Энэ үеүдэд салхи ихэнх нутгаар 12-14 м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн дунд үеэр Алтайн салбар уулсаар, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцэс, гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үе, мөн сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с, зарим үед 24-28 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурах төлөвтэй.

Төвийн нутаг Энэ сард агаарын дундаж температур Дархадын хотгор, Хэнтийн уулсаар 4 градус хүйтнээс 1 градус дулаан, бусад нутгаар 2-7 градус дулаан байх ба ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр хүйтэрч Дархадын хотгороор шөнөдөө 21-26, өдөртөө 3-8 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн эх болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эх ба сүүлийн хагаст харьцангуй дулаарч шөнөдөө Дархадын хотгороор 4-9 градус хүйтэн, бусад нутгаар 1 градус хүйтнээс 4 градус дулаан, өдөртөө Орхон-Сэлэнгийн хөндийгөөр 17-22, бусад нутгаар 14-19 градус дулаан байна. Бусад хугацаанд Дархадын хотгор, Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан, Өвөрхангай, Булган, Сэлэнгийн зарим нутгаар 13-18 градус дулаан байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хөвсгөл, Булганы хойд, Сэлэнгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Хөвсгөлийн баруун өмнөд, Архангайн баруун, Өвөрхангайн зүүн хойд, Төв аймгийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орно. Хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас,



уулархаг нутгаар нойтон цас орно. Энэ үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с, ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр зарим үед 18-20 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурах төлөвтэй.

Зүүн зүгийн нутаг Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар 3-8 градус дулаан байх ба нутгийн зүүн хэсгээр олон жилийн дунджаас 0.5 градусаар хүйтэн, бусад хэсгээр олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн эх болон сүүлийн хагаст хүйтэрч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 12-17 градус хүйтэн, өдөртөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр бага зэрэг хүйтэрч шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Харин гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст харьцангуй дулаарч шөнөдөө ихэнх нутгаар 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө Хэнтийн уулархаг нутгаар 13-18, бусад нутгаар 17-22 градус дулаан байна. Бусад хугацаанд нутгийн хойд хэсгээр шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Хэнтийн зүүн хойд, Дорнодын ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, харин Хэнтийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар цас орно. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, харин сүүлчээр нь нутгийн хойд хагаст хур тунадас, Хэнтийн уулархаг нутгаар нойтон цас орно. Энэ үеүдэд ихэнх нутгаар салхи 12-14 м/с байх ба ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эцэс, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар 18-20 м/с, зарим үед 24 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Говийн нутаг Энэ сард агаарын дундаж температур өмнөд говиор 7-12, бусад нутгаар 3-8 градус дулаан байх ба ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([3 дугаар зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн эх болон сүүлийн хагаст ихэнх нутгаар шөнөдөө 8-13 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Харин гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст бүх нутгаар харьцангуй дулаарч шөнөдөө 3-8, өдөртөө 18-23 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан, өдөртөө 13-18 градус дулаан байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Өмнөговийн баруун ба зүүн өмнөд, Дорноговийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, Говь-Сүмбэрийн нутаг, Дундговийн хойд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)). Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр цас орно. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн хойд ба зүүн хэсгээр хур тунадас орно. Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон эцэс, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе мөн сүүлчээр ихэнх нутгаар салхи 16-18 м/с, зарим үед 24-28 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

*** - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*